

## Төслийн нэр: “Хамтдаа суралцъя”

### Хэсэг I. Төсөл санаачлагчийн мэдээлэл.

Аймаг: Хөвсгөл

Сум/дүүрэг: Цагааннуур сум

СЭЭБХ-ны хаяг: Хөвсгөл аймаг Цагааннуур сум 1-р баг Сумын төв

СЭЭБХ-ны Зөвлөлийн дарга: Баасан овогтой Гэрэлмаа

СЭЭБХ-ны Зохицуулагч: Төмөрбаатар овогтой Болор-Эрдэнэ

Манай СЭЭБХ нь 2016 онд байгуулагдаж одоогоор 56 гишүүнтэй, удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн дарга, зохицуулагч, төсөв санхүүгийн нягтлан, гишүүд гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. 2018 оны 9 дүгээр сард СЭЭБХ-ны удирдлагыг сонгох сонгууль болж, Удирдах Зөвлөлийн даргаар Б.Гэрэлмаа, Зохицуулагчаар Т.Болор-Эрдэнэ нар сонгогдож удирдах зөвлөлийн 50 хувь нь эцэг эхийн төлөөлөл сонгогдон ажиллаж байна.

Төслийн санаачлагийн хувьд Сумын удирдлага ИТХурал, Засаг даргын Тамгын Газар, эцэг эх, асран хамгаалагчид, Хармай, Гурвансайхан багийн 86 иргэн, ЕБС-ийн удирдлага, бага ангийн 10 багш нараас тухайн суман дахь бага боловсролд тулгамдаж буй асуудлыг манай СЭЭБХ-нд ирүүлсний дагуу зөвлөл хэлэлцээд “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн заалтад нийцсэний дагуу СУРГУУЛИЙН ЭЦЭГ ЭХ БАГШИЙН ХОЛБОО боловсруулав.

### Хэсэг II. Нөхцөл байдлын шинжилгээ:

Тухайн сумын ЕБС дээр нөхцөл байдлын шинжилгээ хийж тулгамдаж буй асуудлыг даван гарах нэгч гэсэн үр дүнтэй алхам хийх зорилгоор үр дүнг тусгаж СВОТ шинжилгээг хийлээ. Сургалтанд бодит үр дүнг авчрахуйц, төслийн үндсэн зорилготой нийцүүлэн санаачилсан болно.

<b>S- Давуу тал</b>	<b>W- Сул талууд</b>
<p>1. Бага ангийн хүүхдийн сурлагын амжилтыг ахиулах чин эрмэлзэлтэй залуу багш нартай.</p> <p>2. Бага ангийн багш нарын 40% нь мэргэжлээрээ 5 дээш жил ажилласан туршлагатай багш нар ажиллаж байна.</p> <p>3. Бусад сургуультай харьцуулахад цомхон зохион байгуулалттай бөгөөд үндэсний цөөнх цаатан иргэдийн хүүхдүүд суралцдаг.</p>	<p>1. Бусад сургуулиас алслагдмал мэдээллээс хол, харилцаа холбоо интернэтгүй.</p> <p>2. Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо муу</p> <p>3. Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах нөхцөл боломж тааруу учраас эцэг эхчүүд сургуулийн үйл ажиллагаа болон хүүхдийнхээ сурлагыг тэр болгон сайн мэддэггүй.</p>

<p>4. Сургуулийн Эцэг Эх Багшийн холбоотой байгаа нь багш эцэг эх хамтран дуу хоолойгоо нэгтгэн ажиллах давуу талтай</p>	<p>4. Анги танхимын хүрэлцээ муутай тул 3 ээлжээр хичээллэдэг.  5. Анги бүр ердийн галлагаатай тул өвлийн улиралд маш хүйтэн.  6. Тухайн сум хэт алслагдмал тул багш нар туршлага судлах үйл ажиллагаа зохион байгуулахад төсөв сахүүгийн хувьд хүндрэлтэй.  7. Хичээлийн хэрэглэгдэхүүний хүрэлцээ маш муу.  8. Бага ангийн сурагчдын нэлээд хэдэн хувь нь унших, бичих, чадвар муу /сургуулиас эцэг эх нь гаргаж авна гэсэн яриатай байдаг./</p>
<p><b>О- Боломж</b></p> <p>1. Бага ангийн багш нар хүүхэд бүрт анализ хийж сурлагын түвшинг тодорхойлж эцэг эхчүүдэд мэдээлэл өгөх.  2. Эцэг эхийн хандлагыг өөрчлөх зарим сургалт зохион байгуулах.  3. Дутагдалтай байгаа зүйл дээр бусад төрийн болон бусад байгууллага, ТББ-аас тусламж хүсэх боломжтой.  4. Дотуур байранд хичээл давтах тусдаа ерөө гаргаж, дотуур байрын багш нар төлөвлөгөө гаргаж хүүхдүүдийн хичээлийг давтуулах боломжтой.  5. Эцэг эхээсээ хол дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүд ихэвчлэн хичээлээс хоцрогддог тул хичээлийн хэрэглэгдэхүүнийг бий болгосноор хичээлийн бус цагаар хичээл давтах сонирхол нэмэгдэнэ.  6. Хөвсгөл аймгийн бүсийн төв сургуулиас /Дэлгэрмөрөн ЦС/-аас багш нар туршлага судлах боломжтой</p>	<p><b>Т- Эрсдэл</b></p> <p>1. Суралцагч нарын сурлагын амжилтад нөлөөлж буй хамгийн том асуудал 2-с дээш ангид орход эцэг эхийн тусламж багасдаг. /Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ сургалтанд анхаархаа больдог/  2. Багш нарын хичээл заах орчин нөхцөл маш муу /анги танхимын хүрэлцээ муу хүйтэн тул өдөрт ихэнхдээ 2 ээлжээр хичээллэдэг/  3. Дотуур барын хүүхдүүдийг анхаарах хичээл давтуулах үйл ажиллагаа орхигдох магадлалтай.  4. Тухайн суманд хөдөө тайгад амьдардаг цаатан иргэд олон (орон зайн хувьд хол) тул идэвх зүтгэлийн хувьд тааруу байж болзошгүй.</p>

## Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

**Зорилго:** Сумын **сургуулийн** бага ангид суралцаж байгаа хүүхдүүдийн сургалтын амжилтыг сайжруулахад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнийг оновчтой бий болгосноор сурагчдын хичээл хийх идэвхийг мэдэгдэхүйц нэмэгдүүлнэ.

Тухайн сумын сургуульд эцэг эхийн оролцоо муу байснаас 2-оос дээш ангиудад хичээлийн хоцрогдол их байдаг. Эцэг эхчүүд хүүхдээ 1 дугаар анид ороход хичээлд нь анхаарал тавьж хичээл хийлгүүлэх үйл явц идэвхтэй өрнөж байдаг. Хүүхэд уншиж, бичиж тоо тоолж сурахын хирээр эцэг эхийн зүгээс “санаа амарлаа” гэсэн үзэл нөлөөлж хичээл давтуулах, сургах үйл явцад ач холбогдол өгөхгүй болж эхэлдэг. Уншиж бичиж сурсан юм чинь гээд бүр хичээлээс гаргаж авах тохиолдол цөөнгүй гардаг. Энэ нь эцэг

эхийн идэвхгүй байдалтай шууд холбоотой юм. Үүнийг засаж зөв гольдролд нь оруулж эцэг эхийн зүгээс хүүхдээ анхаардаг, боловсролтой сайн хүн болгохын төлөө мэрийдэг, хүүхдийнхээ төлөө ямар ч завгүй, ажилтай байсан ч цаг зав гаргадаг хүүхдийнхээ боловсролыг ойлгодог болох юм.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр 265 сурагч, бага боловсролын 11 багш, сургуулийн удирдлага, 300 гаруй эцэг эх бүр төслийн үр шимийг хүртэх юм. Эцэг эхийн оролцоог бодитоор нэмэгдүүлж, сургуулийн дотуур байранд хичээл давтуулах өрөө гаргаж байрын багш нарыг идэвхтэй ажиллуулах, хичээлийн хэрэглэгдэхүүн бий болгох зэрэг олон зүйлийг хийх боломж бүрдэж хүүхдийн боловсролд нөлөөлөх ач холбогдолтой юм.

### Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

Д/д	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Сум, Хармай багийн Соёлын төв дээр төслийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах	СЭЭБХ-ны УЗ, Сургуулийн удирдлага, сумын болон багийн удирдлагууд	2019 оны 6-р сард	СЭЭБХ-ны үйл ажиллагаа, төслийн талаар эцэг эх бүр мэдээлэл авч үүрэг хариуцлагаа мэдэж авах, СЭЭБХ-ны гишүүнчлэл нэмэгдэнэ. Эцэг эх, сумын удирдлага, сургуулийн багш, ажилчдыг урьж оролцуулах, хөдөөгийн эцэг эхчүүд оролцох боломжийг бүрдүүлэх ойртох зорилгоор үйл ажиллагааг давхар зохион байгуулна.
<b>Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх</b>				
2.	ССДА-ыг шинэ хамтарсан багаар хэрэгжүүлэх	СЭЭБХ	2019 оны 9-10-р сар	СЭЭБХ-ны УЗ эцэг эх, багш, сурагч, сургууль, сумын удирдлагаас бүрдсэн хамтарсан багийг шинээр бүрдүүлж, чиглүүлж ажиллана.
3.	ССДА-ыг хэрэгжүүлсэн тайлан, зөвлөмж боловсруулах	СЭЭБХ, хамтарсан баг	2019 оны 10-р сар	Материаллаг, сэтгэл зүй, засаглалын орчны тайланг боловсруулж, сайжруулах талаар сургуулийн захиргаа, сумын холбогдох байгууллагууд хамтран ажиллана.

4.	Сургуулиа дэмжих үйл ажиллагаа төлөвлөх	СЭЭБХ, хамтарсан баг	2019 оны 10-р сар	СЭЭБХ, сургуулийн удирдлага юу хийхийг тус бүрд тодорхой төлөвлөх, сум, аймгийн удирдлагуудад хандаж шийдүүлэх асуудлыг <b>сургуулийн захиргаатай хамтран</b> төлөвлөнө.
5.	Төслийн үйл ажиллагаа болон ССДА-ыг хэрэгжүүлж байгаа талаар “Хүйн радио”-гоор мэдээлэл хүргэх	СЭЭБХ, хамтарсан баг	2019 оны 10-р сар	ССДА нь ямар зорилготой, хамтарсан багт хэн хэн ажиллаж байгаа, сургуулийн 3 орчныг сайжруулснаар сурлагын амжилтад үзүүдэх нөлөө, ач холбогдлын талаар ярина.
<b>Сургуулиа дэмжих үйл ажиллагаа</b>				
1.	Материаллаг орчин: Сургуулиа дэмжих үйл ажиллагаагаар <b>”Хүүхэд хөгжлийн танхим”</b> байгуулах	СЭЭБХ	2019 оны 11-12-р сар	Дотуур байрны болон бусад сурагчид хөгжих боломж бүрдэнэ. ССДА-ын тайланд хичээл хийх, хүүхэд хөгжих орчин бүрдээгүй гэж удаа дараа гарсан. Эцэг эхчүүд ирж тогтмол тусалдаг болно.
2.	Сэтгэл зүйн орчин: СЭЭБХ Хүүхдийн эрх, хамгааллын сургалтыг сургуулийн хамт олонд зохион байгуулах	Төслийн зөвлөх Ч.Лхагвасүрэн, аймгийн ГБХЗХГ-ын хүүхэд хамгааллын мэргэжилтэн.	2020 оны 1-р сар	<b>Сурагчид</b> ялангуяа дотуур байрны хүүхдүүд эзэнгүй орхигдохгүй бөгөөд хичээлийн бус цагаар хичээл давтах, давтуулах туслагчтай болно. Сургуулийн удирдлагын зүгээс хүүхэд хамгааллын баримт бичиг боловсруулж, бүх талын саналыг авч батлах, хэрэгжилтэд СЭЭБХ хяналт тавьж ажиллана.

3.	Засаглалын орчин: Төрийн өмчийн сургуулийн төсвийн зарцуулалтын мониторинг хийх аргачлалыг хэрэгжүүлэх: 2019 оны 9-12-р сарын төсвийн зарцуулалтад мониторинг хийнэ.	Төслийн зөвлөх Ч.Лхагвасүрэн, Аймгийн БСУГ-ын төсвийн мэргэжилтэн Н.Далайжаргал нар хариуцан 2 өдөр ажиллана.	2020 оны 1-р сард сургуульд очиж ажиллана.	Засаглалын орчинд сургуульд төсөв хангалттай хуваарилагддаг эсэх, Хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх зэрэг ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд анхаарч зарцуулагддаг эсэх, Төсвөө хэр бодтой төлөвлөдөг, Төсвөө зөв, үр ашигтай зарцуулдаг уу гэсэн мэдээллийн ил тод байдлыг хангах, төсөв төлөвлөлт, зарцуулалтад эцэг эхээс санал авдаг үйл явцыг эхлүүлнэ.
4.	ССДА-ыг хэрэгжүүлсэн үр дүн болон СЭЭБХ-ноос хийж буй сургуулиа дэмжих үйл ажиллагааны талаар “Хүйн радио”-гоор мэдээлэл хүргэх	СЭЭБХ, хамтарсан баг	2020 оны 2-р сар	Хамтарсан багийн гишүүд санал сэтгэгдлээ хуваалцана.

**Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх**

1.	Сумын шийдвэр гаргагчидтай нөлөөллийн уулзалт зохион байгуулах	СЭЭБХ-ны УЗ, бусад гишүүд, сургуулийн удирдлагууд	2020 оны 3-р сар	<ul style="list-style-type: none"> <li>СЭЭБХ-ны үйл ажиллагаа, ач холбогдол, ССДА-ыг хэрэгжүүлсэн үр дүнгийн тайланг танилцуулна. Мөн сургуулиа дэмжих үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулж байгаа ажлыг танилцуулна.</li> <li>Сургуулийн түвшинд шийдвэрлэх боломжгүй асуудлуудыг Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгчдөд танилцуулж, шийдвэрлүүлэх талаар хариу авна.</li> </ul>
----	--	---	------------------	--

**Сайн туршлагаа хуваалцаж, суралцах**

1.	Аймгийн төвийн Мөрөн “Гурван-Эрдэнэ” СЭЭБХ, Цагаан-Уул сумын СЭЭБХ руу туршлага судлах, өөрсдийн	СЭЭБХ-ны УЗ, Төслийн зөвлөх Ч.Лхагвасүрэн	2020 оны 3-р сард (Улирлын амралтаар)	Бусад СЭЭБХ-ны үйл ажиллагааны туршлага судална. Туршлага судлах багийн оролцогчид ямар үүрэгтэй оролцохоо хуваарилж авна: -чиглүүлж явах, -зураг авах, бичлэг хийх
----	--	---	---------------------------------------	---

	туршлагыг хуваалцах			-тэмдэглэл хөтлөх (ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг, эцэг эх хэрхэн оролцдог, сум, сургуулийн удирдлагын зүгээс ямар дэмжлэг үзүүлж ажиллаж байна, хамтран ажилладаг эсэх, сумын удирдлагуудад нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг эсэх зэрэг сонирхсон асуултуудаа асууж тэмдэглэнэ, яриаг бичиж авна)
2.	СЭЭБХ-дын үйл ажиллагаа болон бага боловсролд хэрэгжиж байгаа төслийн үр дүн явцыг олон нийтэд мэдээлэх	Цагааннуур сумын СЭЭБХ, Мөрөн “Гурван-Эрдэнэ” СЭЭБХ	2020 оны 3-р сард  (Улирлын амралтаар)	Мөрөнд туршлага судлах явцад орон нутгийн телевиз болон бусад мэдээллийн хэрэгслээр, ил тод ажиллах, олон нийтийг хүүхдэдээ анхаарах тал дээр уриалах үйл ажиллагааг зохион байгуулна.
3.	Буцаж очоод сургуулийн хамт олонд тайлагнана.	СЭЭБХ-ны оролцогчид	2020 оны 4-р сард	Сумын иргэдэд тайлагнах, “Хүйн радио”-гоор 3 удаагийн нэвтрүүлэг бэлдэж нэвтрүүлнэ.
4.	Бага боловсролын нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, төслийн дунд хугацааны тайланг танилцуулах	СЭЭБХ-ны УЗ	2020 оны 5-р сар	Төслийн дунд хугацааны тайланг танилцуулна. Мөн эцэг эхчүүд хүүхдэдээ илүү анхаарч хамтран ажиллахыг уриална.
<b>Эцэг эхийн оролцоотой сурлагын амжилтыг сайжруулах</b>				
1.	<b>“Хүүхэд хөгжлийн танхим”</b> -д дотуур байрны хүүхдүүдтэй ном унших цагтай болох	СЭЭБХ-ны УЗ	2019.1-р сараас тогтмол	Эцэг эхийг зохион байгуулж, хуваарийн дагуу ажиллана. Суралцагчдын унших чадвар сайжирна.
2.	Сумын төвийн хүүхдүүд <b>“Хүүхэд хөгжлийн танхим”</b> -д эцэг эхтэйгээ хамтран ажиллах	СЭЭБХ-ны УЗ	2019.1-р сараас тогтмол	Эцэг эх, хүүхдүүд хамтран ном унших, ярилцах, шинэ бүтээл хийх, сумын хүүхдүүд чөлөөт цагаараа хийх ажилгүй байдаг тул хөгжих бүх боломжийг сүвэгчилж ажиллана.

3.	Эцэг эхийн багууд хуваарийн дагуу "Хүйн радиогоор" ярилцлага хийх	СЭЭБХ-ны УЗ, Эцэг эхийн багууд	2020 оны 5-р сар	Уншлагын цагийн ач холбогдол, ямар аргаар хүүхдүүдтэйгээ уншвал илүү үр дүнтэй байгааг болон эцэг эхчүүд энэ сард би хүүхдэдээ ингэж анхаарал тавьсан сургууль дээр тэдэн удаа очсон ийм хичээл дээр хүүхдэдээ анхаарах хэрэгтэй юм байна гэх мэтээр туршлагаа хуваалцана.
4.	Уншлагын чадварыг үнэлэх	СЭЭБХ-ны УЗ, захирал, бага боловсролын менежер	2020.2-р сараас сар бүр	Сургуулийн захирал, бага боловсролын менежертэй унших чадварын ахицыг үнэлэх хуудас боловсруулж, сар бүр үнэлэх, СЭЭБХ-ны гишүүд оролцож тусална.
4.	Төслийн эцсийн тайлан	СЭЭБХ-ны УЗ	2020 оны 9-рын 20-25	Эцэг эхийн оролцоотой сурагчдын уншлага, сурлагын амжилтыг бодитоор үнэлж дүгнэнэ.

#### Хэсэг IV. Зардлын задаргаа

Зардлын төрөл		Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Тус бүрт нь хүрэх үр дүнг бичнэ. (Хүүхдэд ямар бодит үр дүн авчрах, ямар чадварыг эзэмшүүлэх)
Сургалтын хэрэглэгдэхүүн, материалын худалдан	Бичгийн цаас	боодол	10	12,000	120,000	Сургалт, уулзалт, тайлан, өдөрлөг зохион байгуулахад ашиглахад бэлтгэхэд хэрэглэнэ.
	Стенд баннер	ш	1	100,000	100,000	
	Принтерийн хор	ком	3	20,000	60,000	
	Самбарын цаас	боодол	3	18,000	54,000	Сургалт, уулзалтуудад ашиглана.
	Ватум	боодол	3	20,000	60,000	
	Маркер	хайрцаг	8	10,000	80,000	
ССДА хэрэгжүүлэх зардал	Сургуулийн 3 орчныг үнэлэх, тайлан бичих				50,000	Эцэг эх, багш, сурагч, аймаг, сум, сургуулийн удирдлагын төлөөлөл багаар ажиллах, цуглуулсан мэдээлэлд анализ хийх, нэгтгэн дүгнэх, тайлан бичих чадварт суралцана.
	Сургуулиа дэмжих үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах				50,000	

	Хамтарсан багийн урамшуулал				100,000	
Сургалт, чуулга уулзалт	Төслийн нээлт	Удаа	2	100,000	200,000	СЭЭБХ-ны төслийн үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах, эцэг эхийг татан оролцуулна.
	Бага боловсролын нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах	Удаа	1		100,000	
	Төслийн эцсийн үр дүнгийн тайланг танилцуулах	Удаа	1		100,000	
	Сумын удирдлагуудтай нөлөөллийн уулзалт	удаа	1	4x10 хүн	20,000	Сумын удирдах түвшний хүмүүст урилга өгч тэдэнд нөлөөллийн уулзалт зохион байгуулна (Урилга, цайны зардал)
	Сэтгэл зүйн орчныг сайжруулах сургалт, уулзалт-Хүүхдийн эрх, хамгаалал	Эхний өдөр: Эцэг эх Багш Сургуулийн удирдлагууд	15 10 5		420,000 (хоол 300,000, цай 120,000)	Хүүхдийн эрх, хамгааллын сургалтыг сургуулийн хамт олонд зохион байгуулах, сургуулийн удирдлагын зүгээс хүүхэд хамгааллын баримт бичиг боловсруулж, бүх талын саналыг авч батлах, хэрэгжилтэд СЭЭБХ хяналт тавьж ажиллана.
	Нийт эцэг эх, багш нартай уулзалт-Хүүхдийн эрх, хамгаалал	2-дахь өдөр-хагас өдөр			100,000-цайны зардал	Төслийн зөвлөх Ч.Лхагвасүрэн, аймгийн ГБХЗХГ-ын хүүхэд хамгааллын мэргэжилтэн.  Сургалт, уулзалт зохион байгуулах удирдамж хөтөлбөр боловсруулах, үр дүнд нь сургуулийн удирдлагаас хүүхэд хамгааллын баримт бичгийг эцэслэсэн байдлаар авч СЭЭБХ болон СЭЭБҮНХ-нд ирүүлнэ.
	Чиглүүлэгчдийн зардал (замын зардал, буудлын зардал, урамшуулал багтсан)	2 хүн	2 өдөр		600,000	



	Засаглалын орчныг сайжруулах үйл ажиллагааны зардал	Эхний өдөр	12 хүн	120,000 -хоол 48,000-цай	168,000	Төслийн зөвлөх Ч.Лхагвасүрэн, Аймгийн БСУГ-ын төсвийн мэргэжилтэн Н.Далайжаргал нар хариуцан 2 өдөр ажиллана. Эхний өдөр: Төслийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах уулзалт  2 дахь өдөр: СЭЭБХ-той хамтран төсвийн зарцуулалтын мониторингийн мэдээллээ цуглуулна.  Чиглүүлэгчид тайланг нэгтгэж СЭЭБХ болон СЭЭБҮНХ-нд хүргүүлнэ.
		2 дахь өдөр	12 хүн		168,000	
	Чиглүүлэгчдийн зардал (замын зардал, буудлын зардал, урамшуулал багтсан)	2 хүн	2 өдөр		600,000	
	Туршлага судлах – 3 эцэг эх, 2 багш					
	<ul style="list-style-type: none"> <li>Замын зардал: Цагааннуур-Мөрөн-Цагаан-Уул-Мөрөн-Цагааннуур</li> <li>Томилолт</li> </ul>	2 талдаа 5 хоног	5 хүн 5 хүн	30,000	450,000 750,000	
Үйл ажиллагааны зардал	СЭЭБХ-ны УЗ-ийн уулзалтын зардал	удаа	10	10,000	100,000	Сургалт, чуулга уулзалтын бэлтгэл ажлыг хангана.
	“Хүйн радио”-д үйл ажиллагааны дэмжлэг	удаа	1		100,000	
	Харилцаа холбооны зардал, интернэт	УЗ-д			150,000	
	СЭЭБХ-ны өрөөг тохижуулах тавиур, самбар зэргийг хийх зардал				585,940	
	Банкны шимтгэл				30,000	
Бүгд					5,315,940	Монгол банкны 2019.1.8-ны өдрийн ам.долларын ханш 2657.97 төгрөгөөр тооцов.








## Хэсэг V Төслийн тогтвортой байдал

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр манай сургууль эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж, сурагчдийн сургалтад нөлөөлөөд зогсохгүй төслийг цаашид хэрэгжүүлэх бүрэн боломжтой болох нь харагдаж байна. Төсөл дуусгавар болсон ч төслийн үйл ажиллагааг цаашид сайжируулан эцэг эхчүүдтэй хамтран ажиллах бүрэн боломж бий.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр:

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын СЭЭБХ-ны Зохицуулагч:

 /Т.Болор-Эрдэнэ/

Төслийг боловсруулсан:	Эцэг эх:  / Б.Хуганбаяр /	Огноо: 2018 оны 1-р сарын 8-ны өдөр
	Эцэг эх:  / Б.Золбоо /	
	Эцэг эх:  / П.Туяа /	
	Эцэг эх:  / Д.Түмэнжоргал /	
	Багш:  / А.Отгон-Эрдэнэ /	
	Багш:  / Ө.Армунтуяа /	
	Багш:  / Б.Амурсанаа /	

